



АГААР ЦЭВЭРШҮҮЛЭГЧ + ИОНЖУУЛАГЧ АЕ-800

Ашиглалтын заавар



Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө, ашиглалтын заавартай сайтар танилцана уу.

АГУУЛГА

1. Техникийн үзүүлэлтүүд	3
2. Цэвэршүүлэгчийн онцлог	4
3. Бүтээгдэхүүний бүтэц	5
4. Үндсэн шүүлтүүр	6
5. Бүтээгдэхүүнийг байрлуулахад тавих шаардлага	8
6. Шүүлтүүрийг суурилуулах	8
7. Хэрхэн хэрэглэх	9
8. Цэвэрлэгээ ба арчилгаа	12
9. Хийж болох, болохгүй зүйлс	16
10. Сав баглаа боодлын жагсаалт	17
11. Засварлах, цэвэрлэх	13
12. Шүүлтүүрийг солих	14
13. Эвдрэлийг тодорхойлох	15

1.ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүтээгдэхүүний нэр	Агаар цэвэршүүлэгч
Модел №	АЕ-800
Тэжээл	АС 220V-240V
Хүчин чадал	85W
Дуу чимээ (бага)	≤26dB(A)
Ионжуулагч	10 сая/см ³
Цэвэршүүлэх агаарын хэмжээ	800 м ³ /цаг
Формалдегид агаарын цэвэршүүлэх хэмжээ	300 м ³ /цаг
Цэвэрлэх талбай	100 м ²
Шүүлтүүр солих хугацаа	Шүүлтүүр #1 2жил, #2 6 сар
Цэвэр жин	14 кг
Бүтээгдэхүүний хэмжээс	400x400x669 мм
Цэвэршүүлэлтүүд	Урьдчилсан шүүлтүүр, идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр, ХЕПА шүүлтүүр, сөрөг цэнэгтэй ионжуулагч ялгаруулагч

2. ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГ

ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Утаа, тоос тоосонцор, формалдегид гэр мэтийн бохирдуулагч хийнүүдээс цэвэршүүлэх
- Агаарын чанарыг сайжруулж амьдрах орчныг оновчтой болгох сөрөг цэнэгтэй ионыг идэвхжүүлэх
- 100 м² хүртэл талбайтай орон сууц, албан тасалгаа, хоолны газар, баар, үзвэрийн газрын агаарыг цэвэршүүлж, ариутгах


ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГ

- Дөрвөн өнгийн ЛЕД гэрэл нь агаарын чанарыг илэрхийлнэ.
- Давхар шүүлтүүр нь хоёр дахин их агаарыг цэвэршүүлж гаргана.
- Өндөр нарийвчлалтай тоосны мэдрэгч нь тухайн үеийн агаарын чанарыг шууд мэдрнэ.
- Унтлагын үе дэх, гараар хийгдэх, автомат удирдлагын систем
- Дөрвөн төрлийн цэвэршүүлэх горим: гараар тохируулах, автомат, хурдны, унтлагын

ШҮҮЛТҮҮРИЙН ОНЦЛОГ

- Үндсэн шүүлтүүр: Хүний үс, амьтны үс ноос, хөвөн зэрэг том ширхэгт зүйлсийг шүүнэ.
- ХЕПА бүтэцтэй шүүлтүүр: ХЕПА шүүлтүүр нь 0,3 микрон болон түүнээс том хэмжээтэй нян, утаа, тоос, аллерги үүсгэгч, бохирдуулагч болон бусад жижиг хэсгүүдийг 99% дээш хувиар шүүх чадвартай. Мөн бензин, формалдегид, эвгүй үнэр зэрэг хорт бодисуудыг шүүх чадвартай.

3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮТЭЦ




Алсын удирдлага


Нүүрсний нягтаршуулсан
даавуун шүүлтүүр

Нүүрсний нягтаршуулсан
даавуун шүүлтүүр

Хойд тал




Үндсэн шүүлтүүр



Их бие

Урд тал



Үндсэн шүүлтүүр

4. ҮНДСЭН ШҮҮЛТҮҮР



Дээд дэлгэц



Урд дэлгэц

Дэлгэцэн дээр on/off товч, үйлдлүүдийн товч, хэрэглээний байдлын дэлгэц, ажиллаж буй байдал харагдана.

1. On/off товч, үйлдлүүдийн товчны харагдац

	Standby	On
On/off key	 Улаан	 Ногоон
Үйлдлүүдийн товчны харагдац		
Mode 	Speed 	Child lock 
Timer 	Filter 	Auto 
Speed 	Sleep 	

2. Шүүлтүүрийг солих сануулга

Энэ төхөөрөмж шүүлтүүрийг солих цагийг сануулах тогтмол үйлдэлтэй бөгөөд 3000 цагийн дараа солих, төхөөрөмж заасан цаг ажиллахад дэлгэц дээрх гэрэл асч хэрэглэгчийг шүүлтүүрээ солихыг сануулна. Энэ товчийг дарснаар ажиллах хугацаа дахин эхэлж, үйлдлийн систем шинээр ачаална.

	Энгийн	Дууссан	
Үндсэн шүүлтүүр	Дэлгэцэнд харагдахгүй		Тод улаан гэрэл торыг цэвэрлэхийг сануулна
ХЕПА шүүлтүүр	Дэлгэцэнд харагдахгүй		Тод улаан гэрэл шүүлтүүрийг солихыг сануулна


Агаарын чанарын үзүүлэлтийн гэрэл



3. Агаар чанарт хариу үзүүлэх хүснэгт

PM 1.0 чадал ug/m ³	5-35	36-75	76-150	151-500
Агаарын чанар	Сайн (ногоон)	Хэвийн (цэнхэр)	Муу (улбар шар)	Бохирдолтой (улаан)
Хурд	чимээгүй	Дунд	Өндөр хурд	Турбо хурд
Хурдны үзүүлэлт	• • •	• • • •	• • • • •	• • • • • •

5. БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БАЙРЛУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА




Цэвэршүүлэгч ажиллаж байх үед хананаас хойд талд нь 20 см хоёр талд нь 30 см зайтай байлгана.

6. ШҮҮЛТҮҮРИЙГ СУУРИЛУУЛАХ


1. Шүүлтүүрийг гялгар уутнаас гаргаж авах

а. Нүүрэн тал болон хойд талыг онгойлго.

б. Шүүлтүүрийг ав.




с. Шүүлтүүрийг тээвэрлэлтийн сав уутнаас гарга.




д. Хэрэглэхээс өмнө шүүлтүүрийг уутнаас нь гаргасан эсэхийг шалгах.

2. Шүүлтүүрийг болон нүүрэн талыг суурилуулах

а. Тоосны шүүлтүүрийн дотор ба гадна тал нь ялгаатай. Анхаар: Бариултай тал нь гадагш харуулж хийгдэх ёстой.



б. Урд шүүлтүүрийн дотор ба гадна тал нь ялгаатай. Анхаар: Бариултай тал нь гадагш харуулж хийгдэх ёстой.



с. Урд хойд талын тагийг хийнэ.



д. Тагнуудыг хийгээгүй үед төхөөрөмж ажиллахгүй.

7. ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ

1. Цахилгаан хүчдэлд залгах

Төхөөрөмжийг хамгийн анх хэрэглэхдээ, хайрцаг савнаас нь гаргаад залгуурын утасны бэхэлгээг салган тогонд залгана. Тогонд залгасны дараа дэлгэц дээрх товчны гэрэл улаанаар асна.

Auto товч



Power
товч




POWER товчийг хөнгөн дарснаар жингэнэх чимээ гарч асаах товч ногоон болон төхөөрөмж автомат горимд орно. Тэр үед төхөөрөмжийн дэлгэцэн дээр AUTO (автомат горим) зэрэгцэн асна.

2. MODE сонгох: Төхөөрөмж ажиллаж байхад, Mode товчийг дарж automatic, sleep, turbo, manual гэсэн 4 горимоос сонгоно. Auto гэрэл асаалттай үед negative ion (сөрөг цэнэгтэй ионжуулагч) асах ба моторын хурд нь мэдрэгчээс хурд солих өгөгдлийг хүлээж авна. (автоматаар ажиллах горим идэвхтэй үед дүрсийн гэрэл нь асаалттай, автомат горим ажиллаагүй үед гэрэл нь хагас ассан байна). Turbo гэрэл ассан үед хурдны үзүүлэлт ассан байх ба хурдан цэвэршүүлэх горимд орсон байна. Sleep гэрэл ассан үед унтлагын горим идэвхжиж төхөөрөмжийн гэрлийн хурц байдал нь тал хувиар багасна. Төхөөрөмж мэдрэгчээс удирдагдахгүйгээр зөвхөн унтлагын горимоор ажиллана.

Хэрэв та Timer горимыг идэвхжүүлвэл, хугацаа нь хойд хэсэгт ердийнөөр ажиллах ба хугацаа болмогц төхөөрөмж түр зогсолтын байдалд орно.




3. MANUAL MODE: Төхөөрөмж ажиллаж байхад, wind speed (сэнсний хурд) товчин дээр төхөөрөмжийн ажиллах хурдыг тохируулахын тулд моторын хурдыг солих гэж дарна. Моторын хурдыг ингэж гараар тохируулвал мэдрэгчээс удирдагдахгүй бөгөөд суулгасан хурдаар зөвхөн ажиллах болно. (Ухаалаг товчийг дарсны дараах ухаалаг товчны байрлах сэнсний хурдан дээр)



4. CHILD LOCK: Төхөөрөмжийг асаалттай үед энэ товчин дээр 5 секундын турш дарахад бүх товч түгжигдэх ба үүний дараа ямар ч товчин дээр дарсан ажиллахгүй бөгөөд өмнө нь ажиллаж байсан тэр горимоороо ажилласан хэвээр байна. Энэ товчин дээр дахин 5 секундын турш дарснаар төхөөрөмж энэ горимоос гарна. (Child lock горимоор ажиллах үед дүрс асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй.)



5. TIMER: Төхөөрөмжийг асаалттай үед товчин дээр дарахад цагийн горим унтрана. Төхөөрөмжийг ажиллаагүй үед, энэ товчин дээр дарахад цагийн тохиргоо хийх гэж дарна. Дарах тоо тутамд цаган дээр нэг цаг нэмэгдэнэ. Энэ нь хуримтлагдан 12 цаг болох үед, нэг илүү дарахад унтрана. Хугацааг 1-12 цагийн хооронд суулгаж болно. (Дүрс төхөөрөмжийг цагийн горимоор ажиллах үед асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй.).



8. ЦЭВЭРЛЭГЭЭ БА АРЧИЛГАА

1. Үндсэн шүүлтүүр: Цэвэрлэх давтамж нь сэнсний хурд, агаарын бохирдол, хуримтлагдсан хугацаанаас шалтгаалдаг бөгөөд жирийн тохиолдолд 2-3 сар тутамд цэвэрлэнэ.


- Шүүлтүүрийн гадаргууг тоос сорогчоор соруулах буюу усаар угаана. Бүрэн хатсаны дараа хэрэглэнэ.

2. ХЕПА нягтаршуулсан: Энэ нь ХЕПА агууламжтай учир үр дүнтэйгээр шүүх шингээгч, цэвэршүүлэгч материал нь тоос тоосонцор, нян бактер, вирус, биетийг шүүж агаараас хорт хий, үнэрийг арилгана.




3. Үндсэн шүүлтүүрийг цэвэрлэх:


- 1) Унтраах товчийг дараад тогноос салгана.
- 2) Бариул дээр гараа тавьж байгаад тодорхой өнцгөөр гадагш нь татаад хойд тагийг дээш нь өргөнө. Шүүлтүүр энэ үед цэвэршүүлэгчээс сална.



- 3) Үндсэн шүүлтүүрийг хоёр талаас нь зөөлөн барьж татаад гаргана. Тоосыг бужигнуулахгүйн тулд болгоомжтой байна уу.




- 4) Тоос болон зунгааралдсан тоосыг тоос сорогч, сойзоор цэвэрлэхээс гадна усаар хэт бохирдолтой бол шингэн савангаар угааж болно. Хатсаны дараа цэвэршүүлэгч рүү буцааж хийнэ. (Гэмтээхээс хамгаалж цэвэрлэж байхдаа нугалж болохгүй.)



- 5) Суурилуулах арга: Нэмэгдэл хэсгийг шүүлтүүрийн доор байрлах нэмэгдэл хэсгийн тохирох ховил руу хийгээд (Шүүлтүүрийн чиглэлийг анхаараарай, 2 гулсах хэсэг нь гадагш харна.), дээд талд байрлах хоногоор түгжинэ.




- 6) Эхлээд ХЕПА шүүлтүүр, үндсэн шүүлтүүр, урд таг гэсэн дарааллаар бүрдлүүдийг тохирох хэсэгт хийгээд, тагийг ховилд хийж тохируулна.



4. Шүүлтүүрийг солих сануулга

- 1) Унтраах товчийг дараад тогноос салгана.
- 2) Хойд тагийг салгаж “Үндсэн шүүлтүүрийг цэвэрлэх” дээрхийн адил үндсэн шүүлтүүрийг авна.
- 3) Солих үзүүлэлтийн дагуу, ХЕПА нягтаршуулсан шүүлтүүрийг авч солиод шүүлтүүрийн гэр лүү дарааллаар нь шинийг хийн шүүлтүүрийн бүрдлийг цэвэршүүлэгч рүү суурилуулна.






- 4) Тогонд залгаад, зогсолтын байдалтай, улаан гэрэлтэй байх үед дахин горим, цагийг суулгахын тулд FILTER товчийг 5 секунд дарна. Ихэнхдээ, асаагаад filter товчийг дарсан үед шүүлтүүрийн ажилласан нийт хугацаа дэлгэцэн дээр гардаг. Нэгж нь цаг. Дээдгэцэн дээр зөвхөн гурван орон харагддаг тул дэлгэц эхлээд мянгат дараа нь зуутаас нэгжийн орон хүртэл харуулдаг(Дараагийн зураг нь 2802 цагийг харуулах аргыг үзүүлнэ.)



- 5) Хамгийн сүүлд тогноос салгаад хойд тагийг их биенд суулгана.

- Тоосны хамгаалалтыг аваад линзийг хөвөн толгойтой цэвэрлэгчээр хөнгөн арч.
- Агаар мэдрэгчийн хаалтны гадрыг тоос сорогч болон үсний сэнсээр цэвэрлэ.



5. Цэвэрлэгээ


Агаар гарах хэсгийн цэвэрлэгээ

- Цэвэрлэгээний алчуураар арч. Энэ төхөөрөмжийг усаар цэвэрлэж болохгүй.




Агаар гарах хэсгийн цэвэрлэгээ

- Унтраах товчийг дараад тогноос салгана.
- Гараа гурвалжин дүрстэй агаарын торон дээр тавиад дээш тат.
- Агаарын торыг ажиллаж байхад нь авахад төхөөрөмж автоматаар ажиллахаа болино, буцаагаад тавихад ажиллахаа үргэлжлүүлнэ.



6. **Тоос мэдрэгч** (ойролцоогоор хоёр сар тутамд нэг удаа)
Тоог арилгахдаа линзийг хуурай хөвөн толгойтой чих цэвэрлэгчийн үзүүрээр арчина. (Чийг болон тамхины утааны үлдэгдэл үүнийг бүрэн бус ажиллагаатай болгосон байх магадлалтай.) Эхлээд тоос мэдрэгчийн тагийг салгаж аваад хуурай хөвөн даавуун чих цэвэрлэгчээр линзийг арчина.

- Энэ цэвэрлэгчийг линзнээс өөр газар хүргэж болохгүй.
- Цахилгааны утсыг салгасан байх ёстой.
- Сайн харахгүй байвал гэрэл хэрэглэнэ үү.
- ажиллахаа үргэлжлүүлнэ.



9. ХИЙЖ БОЛОХ БА БОЛОХГҮЙ ЗҮЙЛС

Аюулгүй ажиллагаа

- Агаарын чанар хэдийгээр тухайн үед сайн бөгөөд автомат горим дээр байсан хэдий ч доторх хэт чийглэгээс үүдсэн чийгшил нь агаарын чанарын үзүүлэлэлт харуулагчид нөлөөлж муу үзүүлэлт, сэнсний хурдыг гараар тохируулахыг сануулах болно.

	Залгуурыг нойтон гараар барьж болохгүй		Цэвэрлэхээс өмнө салгасан эсэхийг сайтар шалгах
	Өөр цахилгааны эх үүсвэр ашиглахыг хориглоно. Зөвхөн 220В-5Гц нь энэ бүтээгдэхүүний ашиглах цахилгаан. Их биеийг онгойлгож болохгүй, засварыг зөвхөн мэргэжлийн засварчнаар хийлгэнэ. Осол гэмтэл, цахилгааны гэмтлээс үүдэх галаас сэргийлж бүтээгдэхүүн лүү ус, шингэн, галд автамхай шингэн хийж болохгүй.		Цэвэршүүлэгч ажиллаж байх үед ард 20 см, 2 хажуу талд 30 см зайтай байлга. Энэ бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ хуурай, хөдөлгөөнгүй газар байрлуулж, халуун зүйл болон хэт чийглэг байдлаас холдуулан ашиглана уу.
	Зэврэлт үүсэхээс сэргийлж их биеийг химийн бодис бусад уусмалаар цэвэрлэхийг хориглоно. Сэнсний орчим гараа болон бусад юмс тавихыг хориглоно. Салгахдаа цахилгааны утаснаас татахыг хориглоно: салгахдаа бариулаас нь барьж болгоомжтой салгана.		Төхөөрөмжийг удаан хугацаагаар ашиглахгүй тохиолдолд цахилгааны залгуурыг салгана уу. Хүүхэд хэрэглэх хүрэхгүй байхад анхаарал тавина уу. Агаарын урсгал цэвэр байх ёстой учраас агаар орох хэсэгт тоос, хөвөн даавуу, үс болон бусад зүйлсийг хийхээс хамгаал.

10. САВ БАГЛАА БООДЛЫН ЖАГСААЛТ

Төхөөрөмж	1 ширхэг
Алсын удирдлага	1 ширхэг
Шүүлтүүр	3 ширхэг
Чийгшүүлэгчийн тор	1 ширхэг
Ашиглалтын заавар	1 ширхэг

11. ЭВДРЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Асуудал	Шалгах/Шийдэл
Асааж чадахгүй байх (Power гэрэл асахгүй)	1. Цахилгааны залгуурыг залгасан эсэх? Цахилгааны үүрэнд залгах 2. Цэвэршүүлэгчийн зүүн баруун агаар орох сайн тагласан эсэх? Баруун зүүн талыг сайн таглах Нүүрэн талыг таглах
Асааж чадахгүй байх (Power гэрэл анивчин, товч хариу үйлдэл үзүүлэхгүй)	Төхөөрөмжийн дээрх агаар орох торыг сайн угсарсан эсэх. Тор нь эгц байх ёстойг шалгах. Дээд агаар орох хэсгийг байранд нь угсар.
Агаар бохир боловч агаарын чанарын үзүүлэлт цэнхэр болохгүй байна.	Цэвэршүүлэгч бохир агаар (тоос)-ыг шингээж авч чадахааргүй газар байрласан байна уу? Өөр газар луу шилжүүлж үз.
Ажиллуулж байх үед цохих, шунгинах чимээ гарах	Ионжуулагч дээр их тоостой байна уу? Ионжуулагчийн тоосыг цэвэрлэх.
Агаар гарах хэсгийн онцгүй үнэр	1. Шүүлтүүр бохирдсон эсэх? Шүүлтүүрийг цэвэрлэх. 2. Шүүлтүүрийг солилгүй удсан эсэх? Шүүлтүүрийг солих.
Цэвэршүүлэгч удаан хугацаагаар ажиллаж байгаа боловч агаарын чанарын үзүүлэлт улаан байна	Тоос мэдрэгч хэт бохир байна уу? Тоос мэдрэгчийг цэвэрлэх
Төхөөрөмж унтлагын горимдоо шилжээд байх	Manual горимоор ажиллаж байна уу? Automatic товчин дээр Автомат горим ажиллаж байгаа эсэхийг шалгах.